

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-12

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д заасны дагуу дахин явуулав/ 4-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан
11 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 54 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, А.Ундраа, С.Цэнгүүн;
Чөлөөтэй: Ч.Анар, Т.Аубакир, Ц.Баатархүү, Х.Булгантуяа, Г.Ганбаатар,
З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Б.Түвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Энхтүвшин;
Тасалсан: Ж.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан,
П.Мөнхтулга, П.Сайнзориг, Б.Тулга, Г.Тэмүүлэн, О.Цогтгээрэл.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д заасны дагуу дахин явуулав/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Г.Нарантуяа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх А.Амармөрөн, референт Б.Ууганцэцэг, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулж байгааг мэдэгдэв.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан

төсвийн тусгай шаардлагад нийцээгүй талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31 их наяд 600 тэрбум төгрөг” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32 их наяд 980 тэрбум” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 28
Бүгд: 30

6.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Сэддорж нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31 их наяд 600 тэрбум” гэснийг “31 их наяд 930 тэрбум” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “30,9” гэснийг “31,2” гэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл “-1 их наяд 380 тэрбум” гэснийг “-1 их наяд 50 тэрбум” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “-1,3” гэснийг “-1” гэж, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд “29 их наяд 552 тэрбум” гэснийг “29 их наяд 859 тэрбум” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “28,9” гэснийг “29,2” гэж, нэгдсэн суурь тэнцэл “2 их наяд 48 тэрбум” гэснийг “2 их наяд 70 тэрбум” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 13
Бүгд: 31

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хороодоос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, ирвэл зохих 54 гишүүнээс 32 гишүүн хүрэлцэн ирж, 59.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 30 минут.*

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Ирц бүрдлээ. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Алдаржавхлан, Батболд, Батсуурь, Бямбасүрэн, Ганхуяг, Лодойсамбуу, Найдалаа, Пунсалмаа гишүүн, Цогтбаатар гишүүн, Үүрийнтуяа гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Лувсанжамц гишүүн, Номин гишүүн, Соронзонболд гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Батнайрамдал гишүүн, Болормаа гишүүн, Ганзориг гишүүн, Заяабал гишүүн, Мөнхсоёл гишүүн, Очирбат гишүүн, Уянга гишүүн, Мөнхчулуун гишүүн нарын 28 гишүүнээр өнөөдрийн ирц бүрдэж, 51,9 хувьтайгаар өнөөдрийн хуралдаан эхэлнэ. Ирцийг танилцуулж дууслаа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хороодын ирц 51,9 хувьтай бүрдсэн тул 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулна. Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Батчимэг гишүүн ирцэд орлоо. Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэгдсэн хуралдаанаас олонхын дэмжлэг авсан санал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцээгүй тул хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод буцаах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг танилцуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд хоёр дахь хэлэлцүүлэг дахин явуулахаар төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод буцааж болно гэж заасны дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг дахин хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ням-Осорын Учрал Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, энэ

Төрийн нарийн нь ирэхгүй юм уу? Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д заасны дагуу Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан саналд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг Тогтвортой байдлын зөвлөлөөс танилцуулна. Хэдэн номер вэ, 5 номер уу, 6 юу? 6 номерын микрофоноо асаая.

Р.Рэнцэнбазар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Рэнцэнбазар. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оны, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал гарсан энэ саналын тухайд.

Энэ санал бол гишүүдэд тараагдсан, дээр нь нэгдсэн хуралдаан дээр бүрэн эхээр нь уншиж танилцуулсан байгаа. Би тийм учраас товчлоод дүгнэлтийн хэсгийг нь уншъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь 1 дүгээрт, Төсвийн хүрээний мэдэгдлийн тухайд дотоодын нийт бүтээгдэхүүн болон суурь тэнцлийн нэрлэсэн дүнд нөлөө үзүүлэхгүй боловч төсвийн хүрээний мэдэгдэл дэх суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байх төсвийн тусгай шаардлагыг зөрчихөөр байна.

2 дугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн төслийн хувьд дотоодын нийт бүтээгдэхүүн төсвийн орлогод болон зарлагын бүтцэд үзүүлэх нөлөөнөөс үүдэн төсвийн төсөлд тусгагдсан суурь тэнцэл дотоодын бүтээгдэхүүний 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэсэн төсвийн тусгай шаардлагыг мөн зөрчихөөр байна.

3 дугаарт, төсвийн хүрээний мэдэгдлийг дагуулан төсвийн зарлагыг өөрчилж болзошгүй байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д заасныг зөрчих нөхцөл үүсэхээр байна. Тийм учраас энийг хоёр дугаар хэлэлцүүлэгт буцаах нь зүйтэй гэсэн чуулган дээр ийм дүгнэлт бид уншсан байгаа.

Х.Ганхуяг: Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй. Төсвийн хүрээ. Асуулт, санал нэг шүү гишүүдээ. Өөр асуулт асуух гишүүн алга уу? Соронзонболд гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Гишүүдийн энэ өглөөний мэндийг хүргэе. Энэ асуудал анхнаасаа ер нь бас хууль зөрчөөд, Байнгын хороон дээр санал хураагдаад, тэгээд дараа дараагийн Байнгын хороон дээр хураагдаад ингээд явсан байгаа. Тэгэхээр ер нь бас энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд энэ асуудлаар бас өөрчлөлт оруулж, ийм асуудал дахиж гаргахгүй байх дээр анхаарах нь зөв юм болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол ингээд иймэрхүү хууль зөрчсөн асуудлууд орж ирээд, тэгээд тэр нь дахин, дахин хэлэлцэгдээд ингээд нэлээн цаг үрсэн ийм асуудал болж байна гэж хувь гишүүний хувьд бодож байгаа. Тийм учраас энэ дээр гишүүдийн хамт энэ Их Хурлын дэгийн тухай хууль дээр өөрчлөлт оруулах дээр ажиллана гэж бодож байна.

Х.Ганхуяг: Үг хэлсэн үү? Үг хэллээ. Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт гарч, хуулийн төсөл хоёр дахь хэлэлцүүлэг рүү Байнгын хороод руу дахин буцсан. Ямар азаар бараг хууль дээр энэ Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж буцаах ийм хуулийн заалт орсон юм байгаа юм. Ер нь хууль зөрчсөн санал хураалтыг хураалгахгүй байх эрх нь Байнгын хорооны даргад байгаа шүү дээ Дэгийн хуулиар.

Гэтэл Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг, төсвийн зарлагын дүн, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхийг хориглочихсон заалтыг зөрчөөд, төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлээд ингээд ороод ирсэн санал дээр зарчмын зөрүүтэй санал дээр анхны Байнгын хороо санал хурааснаас болоод л өнөөдрийн нөхцөл байдал үүсээд ингээд бүтэн нэг хэлэлцүүлэг дахиад хугацаагаар алдчихаж байгаа юм л даа. Тийм учраас гишүүдийн гаргаж байгаа энэ зарчмын зөрүүтэй саналууд дээр, ялангуяа Байнгын хороод энэ чинь бүхэл бүтэн ажлын алба аппарат ажиллаж байна. Байнгын хороод энэ холбогдох хууль зөрчсөн санал хураалтыг хийхгүй байх энэ чиг үүргээ хэрэгжүүлэхгүй бол Байнгын хороотойгоо нийлээд анхнаасаа хууль зөрчөөд явдаг ийм нөхцөл байдал үүсэх нь байна шүү. Энэ маш том сануулга анхааруулга болж орж ирж байна гэж ойлгож байгаа.

Тийм учраас цааш цаашдаа Байнгын хороод дээр хийгдэж байгаа энэ санал хураалт хуулийн дагуу байгаа эсэхэд юуны төлөө бид урьдчилж саналаа өгч байгаа билээ. Байнгын хороодын энэ ажлын алба, хуулийн зөвлөхүүд хяналтаа хийж, ямар санал хураалтыг явуулах юм, ямар санал хураалтыг явуулахгүй байх юм гэдэг дээр шийдэл гаргаж явж байх зайлшгүй шаардлага байгааг өнөөдрийн энэ кейс жишээ харуулж байна гэж ойлгож байгаа. Тэгээд нэгэнт хууль зөрчөөд хийчихсэн ийм үйлдэл Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээр гараад ирсэн учраас өнөөдөр энэ асуудлыг бид дэмжээд, чуулганаар дараагийн асуудлаа яаралтай хэлэлцэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Х.Ганхуяг: Үүрийнтуяа гишүүн маш зөв санал хэллээ. Хүний бодлогын байнгын хороон дээр дэмжигдээд ороод ирсэн санал. Тэгээд Байнгын хороон дээр дэмжигдээд ороод ирэхэд Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороон дээр тэр саналыг хураахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн. Тэгэхдээ ер нь цаашид бид яг энэ Төсвийн хуулиа баталсны дараагаар төсвийн дэгийн хууль, Төсвийн хууль дээр энэ хууль зөрчсөн саналуудыг хураахгүй байх тэр эрхийг нь хуралдаан даргалагчид бас өгөхгүй бол төсвийн дэгийн хууль, төсвийн хууль дээр тэр байдаггүй юм. Орсон саналыг заавал ч үгүй хураалгах болчихоод байгаа юм. Мөн уначихсан саналыг нэг босгодог нэг ийм муу юу байдаг, тэгээд

тэрийг бас босгыг нь өндөр болгож өгөхгүй бол энэ зарим саналууд яалт ч үгүй энэ хуулийн зөрчилтэй саналууд бас орж ирээд байгаа юм. Тэгээд Үүрийнтуяа гишүүн маш зөв санал хэллээ. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

Б.Мөнхсоёл: Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заагдсан дүрмүүдийн 2-ыг зөрчсөн ийм байдалтай буцаж орж ирж байгаа. Тэгээд энэ яг практик энэ байдал нь юуг илэрхийлж байна вэ гэхээр тухайн, тухайн Байнгын хороод дээр ч бай, чуулган дээр ч бай гишүүд дураараа төсвийн зардлыг ялангуяа нэмж болохгүй гэдгийг л сануулж байна гэж бодож байна. Тэр учраас одоо төсвийн төсөв буцаагдлаа, төсвийн ажлын хэсэг үүслээ гэхэд төсвийг нэмэгдүүлсэн тохиолдолд зардлыг ямагт эх үүсвэрийг нь гаргаж ирдэг. Тэгэхээр энийг 1 дүгээрт сайтар ойлгох хэрэгтэй байна. Одоо энэ чуулган дээр гишүүдийн хэлж байгаа үг, байгаа байдлыг анзаарахаар зарим маань анзаарахгүйгээр яг хууль зөрчих ийм байдал руу түлхэж орчих гээд байна. Эргээд нөгөө хуулийн хугацаандаа төсөв хэлэлцэгдэх эсэх нь бас эргэлзээтэй. 3 дугаарт нөгөө Сангийн яамнаас 100 хувь эд нар шийдэхгүй ч гэсэн оруулж базаж ирсэн, нөгөө хамгийн сүүлд хуульд өөрчлөлт орсон зүйл бол ямар ч байсан Их Хурал дээр төсвийн хязгаараас давахгүй байх ийм хуулийн заалтууд байгаа шүү дээ. Тэгээд нэмээд энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийн дүрмүүд байгаа. 2-ыг нь зөрччихнэ гэдэг үнэхээр бас дараа дараагийн удаад санууштай ийм явдал болсон шүү.

Тоо гэж би бас заримдаа хэлдэг. Энэ тоон дээр тоог тоонд хувааж энэ харьцаануудыг гаргаж ирж байгаа шүү дээ. Тухайлбал алдагдал 2 хувиас илүүгүй байх энэ тэр гээд. Тэгэхээр тоондоо л дүйцүүлэхийн тулд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг өсгөх ч юм уу ийм арифметик ийм тооцооллыг ерөөсөө хийж болохгүй. Энэний цаана эдийн засаг явж байгаа, эдийн засагт оролцож байгаа нөгөө аж ахуйн нэгжүүд, иргэдийн аж амьдрал, үйл ажиллагаа явж байгаа гэдгийг гишүүд бид маш ухамсартайгаар хандах ёстой юм гэдгийг л хэлэх хэрэгтэй юм болов уу гэж бодлоо.

Х.Ганхуяг: Манай Мөнхсоёл гишүүн маш зөв санал хэллээ. Пунсалмаа гишүүний микрофоныг өгье.

Б.Пунсалмаа: Гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая. 2026 оны Төсвийн тухай хууль батлагдах дөхчихлөө. Энэ хугацаанд бид төсвийнхөө зардлыг 1,1 их наядаар бууруулж байгаад, багш нарынхаа цалинг дунджаар 2,8 саяд, ахмадуудынхаа тэтгэврийг 8 хувиар өсгөж байгаа юм. Залгуулаад эмч нар маань бас энэ ажил хаялт зарлах гээд байна л даа. Ингээд ер нь шат дараалаад ингээд цалин ер нь нэлээн нэмэгдэх шинжтэй байна. Ер нь энэ бол бас зөв юм байгаа юм. Ингэж байж л ер нь өндөр цалинтай ажилд орохыг хүмүүс илүүд үзэж, халамжийн зардал буурах ийм сайн үр дүн гарч ирнэ. Дэлгүүр хоршоо, эдийн засаг сэргэнэ, тэгээд НӨАТ, гааль, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл хэлбэрээр төсөвт эргээд орлого орж ирнэ. Энийг сайн үр дүн гэж харж байгаа.

Гэхдээ нэг зүйл бий инфляц өсөж магадгүй шүү. Тэгэхлээр энэ инфляцыг өсгөхгүй байхын тулд манай энд Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яамныхан ямар бодлого хэрэгжүүлэх гэж байна вэ? Бидэнд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмсэн учраас инфляц өслөө гэдэг зүгээр мэдээ дамжуулдаг ийм бодлого хэрэггүй байна. Сөргөсөн, энэ эдийн засгийн сөрөг арга хэмжээ, энэ инфляцын эсрэг сөрөг арга хэмжээ, ямар сөрөн тэсвэрлэх арга хэмжээ хэрэглэх юм бэ? Энийгээ бас гаргаж ирэх хэрэгтэй. Улс орон болгон ер нь эдийн засгаа өсгөдөг, тэлдэг. Гэхдээ

тэр хэмжээгээр нь инфляц нь өсөөд байдаггүй, инфляцыг бууруулах арга хэмжээ авдаг. Энэ арга хэмжээг бид энэ жил ер нь ямар бодлого хэрэгжүүлэх гээд байна гэдгийг асууя?

Х.Ганхуяг: Маш зөв асуулт асуулаа. Монголбанк байна уу? Монголбанк хариульъя 4 номер.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Гишүүний асуултад хариульъя. Төсөв дээр эхлээд хэлэхэд төсвийн нийт зардал бол өсөөгүй гэдгийг хэлье. Зөвхөн төсөв зардал хоорондоо гүйж байгаа. Төсвийн нийт зарлага 33,9 байхад инфляцын тооцоог бид 7 хувь гэж хийж оруулж ирсэн, дотроо гүйж байгаа. Гэхдээ хөрөнгийн зардал болон урсгал зардлаас цалингийн зардал руу гүйж байгаа учраас инфляцад бага зэрэг нөлөөтэй. Гэхдээ маш том нөлөөтэй бол байхгүй. Засгийн зүгээс инфляцыг бууруулахад энэ дээр ялангуяа өргөн хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн..., гол бодлогоо баримталж ажиллаж байгаа. Монголбанкны хувьд энэ Баярдаваа захирал ирсэн байж магадгүй. Бодлогын хүү буурах орон зай л хумигдаж байгаа гэсэн үг тэрний цаана. Цалин нэмэгдүүлсний цаана. Гэхдээ инфляцад бол тийм том нөлөөгүй гэдгийг энд хэлье.

Х.Ганхуяг: Хариулт хангалттай юу Пунсалмаа гишүүнээ? Нэмж хариулах уу? Гүйцэд хариульъя 4 номер.

Л.Энх-Амгалан: Би нэмж хариульъя. Инфляц дээр нийлүүлэлтийг тогтвортой, гол бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийг тогтвортой байлгана гэдэг дээр Засгийн зүгээс 2, 3 асуудал дээр л чиглэж ажиллаж байгаа. Нэг нь хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, ялангуяа махны нийлүүлэлт. Махны нийлүүлэлтийг тогтвортой байлгахад элдэв янзын Улаанбаатар луу нийлүүлэгдэх явцад бий болдог саад тотгор, хяналт шалгалтыг бага болгох, худалдааг илүү чөлөөтэй болгох дээр бодитой арга хэмжээнүүд хийж байгаа. Нөгөө талдаа хилийн боомтууд дээр аливаа гацалт үүсгэхгүй байх дээр яг хариуцсан яамд нь тодорхой арга хэмжээнүүд төлөвлөж хэрэгжүүлнэ гэсэн ийм хэлэлцүүлэг болсон.

Энэ төсвийн хүрээг Их Хуралд оруулж ирэхийн өмнө Засгийн газар дээр инфляцын зорилтыг 7 дээр барихын тулд ерөнхийлөн сайд бүр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ гэдэг дээр тодорхой арга хэмжээнүүд хоорондоо төлөвлөж, ярилцсан байдаг. Тэрэн дээр бол Зам, тээврийн сайд логистик тээвэр.../минут дуусав/

Х.Ганхуяг: Пунсалмаа гишүүнд микрофон өгье.

Б.Пунсалмаа: Инфляцыг 7 хувьд барина гэх юм, инфляц 7 хувь чинь ч гэсэн өндөр шүү. Энэ 7 хувийг бууруулах тал дээр л ажиллах ёстой байхгүй юу. Тэгээд та бол би таныг төрийн хариуцлагатай албан тушаалтан мэдэгдэл хийж байна гэж ойлгож байна. Ирэх жил бол энэ инфляц өсөхгүй гээд хэлчихлээ. Тэгээд та энэ хэлсэн үгэндээ бат нот зогсоорой, тэрнийхээ төлөө ажиллаарай гэж хүсэж байна. Ирэх жил мах, сүү, гурил, будааны үнэ өсөхгүй байх нь л бидний зорилго. Тэгэхгүй бол ахиад л 7, 8 хувийн өсөлт хийчихвэл энэ их ахмадуудын маань тэмцсэн тэмцэл, бүх энэ зүтгэлүүд талаар нэг болох нь. Тэгэхлээр та бүхэн минь энэ тал дээр бас хичээнгүйлэн ажиллахыг хүсэж байна.

Х.Ганхуяг: Санал хэллээ. Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Надад нэг ийм зарчмын санал байх юм Ганбат даргаа, Монголбанкныхан. Хэдүүлээ Улсын Их Хуралд Төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг яриад, параметр тоогоо батлаад макро эдийн засгийн тэгээд явж байвал яасан юм бэ? Ингээд 2027, 28 гээд 3 жилийн дараагийн төсвийн төсөөллийг яриад, баахан хүмүүсийн толгойг эргүүлээд, нөгөөдүүл нь төсөв байна гэж ойлгоод, тэн дээр юм оруулах гэж дайраад байна шүү дээ. Ийм, одоо чинь төсвийг тооцоолоход хэцүү байна шүү дээ. Төсвийн орлого ирэх жил ямар байх нь хэн ч мэдэхгүй байна шүү дээ. Тэгэхэд бүүр 28 оны төсвийн төсөөлөл энэ тэр гээд ийм сонин юмыг Их Хурал дээр ярьж батлах шаардлага байна уу даа. Зүгээр төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг батлаад, макро эдийн засгийн параметр тоог нь тогтоолоор баталчихвал тэгээд болчих юм биш үү? Тэгэхгүй 2027-гоос 28 оны төсвийн төсөөлөл гээд ороод ирэнгүүт манай гишүүд чинь төсөв байна, би ийм юм суулгана гээд л ингээд сандарч байна.

Тийм учраас ер нь хэдүүлээ энэ хуульдаа өөрчлөлт ороод, мэдэгдлээ нэг ярьчихдаг, төсвөө нэг ярьчихдаг л байвал яасан юм бэ? Тэгээд Их Хурал дээр ингээд л маш олон төсөв яригдаад л, баахан хүн амьтан толгой эргэлдүүлээд байна шүү дээ. Тийм учраас энэ төсвийн төсөөллийн гэдэг юмаа ерөөсөө больчихвол яасан юм бэ, 2027-гоос 2028 он энийг хэн ч мэдэхгүй, зэс ямар үнэтэй байх юм, нүүрс ямар үнэтэй байх юм хэн ч мэдэхгүй байна. Тийм учраас хэдүүлээ энэ дээр нэг ийм бодлогын шинэчлэл хийвэл яасан юм бэ, ийм саналтайтай байна. Энийг хариулж өгөөч энэ дээр.

Х.Ганхуяг: 1 номерын микрофон өгье.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Ер нь зүгээр бусад орнууд дээр, энэ асуудал өмнө нь бас хэд хэдэн удаа яригдаж байсан. Өмнөх 16, 7 оны үед, тэрнээс өмнө ч яригдаж байсан. Жишээ нь бид, жишээ нь Норвег энэ тэр гээд зарим ихэнх орнуудад төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурал баталдаггүй. Төсөөлөл байдлаар өөрөө танилцуулдаг. Томоохон хэмжээний өөрчлөлт орвол тэр асуудал дээрээ парламент дээрээ нээлттэй хэлэлцүүлэг хийдэг ийм байдлаар юмнууд явдгийг бол Сангийн яам бас нэлээн судалж үзсэн юмнууд байгаа. Бид Валютын сантай энэ асуудлаар зөвлөлдөж, санал солилцсон юмнууд байгаа. Валютын сан болон Дэлхийн банк, олон улсын байгууллагуудаас манайд зөвлөмж өгдөг нь танайх бол яг ийм байдал руу шилжих арай болоогүй. Санхүүгийн сахилга батыг нэлээн чанд мөрддөг, тогтвортой ийм өсөлттэй ийм байгаа үед яг ийм байдлаар төсвийн хүрээ заавал батлахгүйгээр, төсөөлөл байдлаар парламентад танилцуулаад, томоохон хэмжээний өөрчлөлтүүдийгээ хэлэлцүүлэг байдлаар хийгээд явж болох юм гэдэг ийм байр суурийг илэрхийлдэг. Бид энийг байнга асууж ийм байдлаар явдаг.

Ер нь бусад орнуудын жишээг харахад яах вэ бүтэн жилийн төсвөө өөрөөр хэлбэл төгс төгөлдөр хийгээд байдаг орон бол аягүй хүнд шүү дээ. Бүх газар л ингэж төсвөө тодотгож байна. Ийм тохиолдолд 3 жилийн төсвийн төсөөллийг бас ингээд батлаад, тэрийгээ чанд мөрдөнө гэхэд өрөөсгөл байгаа юм. Зүгээр яах вэ яг санхүүгийн сахилга бат, саяын миний хэлдэг энэ асуудлын хувьд манай дээр энийг хэзээ, яаж мөрдөх вэ гэдгийг энэ төсвийн шинэчлэлийн хүрээндээ ингэж цогцоор нь авч үзэх нь зүйтэй юм гэдэг ийм байр сууриас бид хандаж байгаа.

Х.Ганхуяг: Алдаржавхлан гишүүн тодруулна.

Ж.Алдаржавхлан: Манай Учрал сайд энийг анхааралдаа авч байгаа байх гэж би бодож байна. Ерөөсөө 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийг хууль хэлбэрээр батлаад бид яваад байна шүү дээ. Гэтэл өнөөх төсөв дээр бид чинь орж ирээд, ажлын хэсэг ажиллаад, ингээд төсөв маань үндсэндээ бараг танигдахын аргагүй болж байна. Тэгэхлээр яаж хэдүүлээ 3 жилийн дараагийн төсвийн төсөөллийг хуулиар батлаад, мөрдөхгүй юмыг ингэж энд хэлэлцэж цаг, та нарын цагийг ч аваад, та нарыг энд авчирч байцаагаад, бид энд нэг ухаантай юм яриад ч хэрэггүй байх. Тийм учраас ирээдүйн төсвийн шинэчлэлийг хийхдээ, эрх зүйн шинэчлэлийг хийхдээ энэ зөвхөн төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг батлаад, ирэх оныхоо төсвийг яриад явдаг л болбол яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм.

Х.Ганхуяг: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Учралын микрофон өгье.

Н.Учрал: Энэ төсвийн хүрээ баталж байгаа бол энэ төсвийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлж байгаа маш чухал ийм бодлого. Хэрвээ төсвийн хүрээг ингэж батлахгүй бол төсөв хязгааргүй нэмэгдэнэ. Тэгээд төсөв хуваарилж байгаа Сангийн яам өөрсдөө төсвийн хүрээгээ боловсруулаад, орлого, зарлагаа дураараа нэмдэг, багасгадаг байвал төсвийн сахилга бат, хариуцлага яриад нэмэргүй болно. Тийм учраас энэ төсвийн хүрээгээ хязгаарыг ингэж тусдаа батлаад, Их Хурал ч гэсэн орлого, зарлага нэмж чадахгүй ийм байдалд байгаа нь маш сайн байхгүй юу. Төсвийн тусгай шаардлагуудыгаа бариад. Хэрвээ ингээд жишээ нь Сангийн яам өөрсдөө төсвийн хүрээгээ ингээд төсвөө хуваарилаад оруулаад ирдэг байсан бол өнөөдөр багш, эмчийн цалин гээд л яахад дураараа зарлагаа нэмээд л явна шүү дээ. Тэгэхээр харин ч энэ төсвийн хүрээ хязгаар байгаадаа өнөөдөр яг энэ рамдаа л бид ярьж байна. Тэгэхээр энэ бол маш зөв бодлого байхгүй юу. Тэгэхээр харин ч бүүр хатуу барих.../минут дуусав/

Х.Ганхуяг: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Төсвийн хүрээг бол дэмжээд байгаа шүү дээ яг хатуу байх ёстой. Энд чинь төсвийн төсөөлөл гээд нэг хууль яваад байгаа байхгүй юу 2027, бүүр 2028 оны төсвийн төсөөлөл гээд, энийг ярьж цаг алдах хэрэг байна уу даа. Төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг яг одоо Учрал сайдын ярьсны дагуу хатуу батлаад явчихъя. Төсвийн төсөөлөл гэж 3 жилийн дараагийн төсвийн төсөөллийг одоо бид ярьж, хуульчилж батална гэдэг чинь өнөөдөр дэлхийн эдийн засаг ийм үед хүндрэлтэй байна, энэ бас цаг алдсан баримт бичиг юм биш үү л гэсэн ийм санаачилга хэлж байгаа юм.

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. 2 санал хураалт байгаа. Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа Боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах саналыг гаргасан бөгөөд энэ санал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцээгүй гэсэн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасны дагуу нэгдсэн хуралдаанаас хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар хамтарсан хуралдаанд буцаасан.

Монгол Улсын чуулганы нэгдсэн, Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т заасны дагуу дээрх саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Батбаяр гишүүн ороогүй байна, Батнайрамдал гишүүн ороогүй байна, Батсүмбэрэл гишүүн ороогүй байна, Батчимэг гишүүн ороогүй байна, Жамбалын Ганбаатар гишүүн ороогүй байна, Лодойсамбуу гишүүн ороогүй байна. Дуудаарай, гишүүдийг дуудаарай. Лувсанжамц гишүүн ороогүй байна, Найдалаа гишүүн ороогүй байна, Номин гишүүн ороогүй байна, Очирбат гишүүн ороогүй байна, Цогтбаатар гишүүн ороогүй байна, Энхцэцэг гишүүн ороогүй байна. Гишүүдээ дуудаарай.

Тэр хооронд саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Төсвийн болон Эдийн засгийн хамтарсан Байнгын хорооны дэмжээгүй санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 их наяд 600 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 он 32 их наяд 980 тэрбум гэснийг 490 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өөрчлөлт оруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй гэсэн байна. Мөнхтуяа гишүүний саналыг, гишүүдийн ирц яаж байна вэ? Гишүүдээ дуудаарай.

Мөнхтуяа гишүүний саналаар санал хураалт явуулна. Дэмжихгүй гэвэл одоо улаанаа дарна, дэмжинэ гэвэл ногооноо дарна гэсэн үг. Санал хураалт, зангианы өнгөөр. Санал дэмжигдсэнгүй. 6,7 хувь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2 дахь санал хураалт. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагийн гаргасан төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 их наяд 600 тэрбум гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32 их наяд 980 тэрбум гэснийг 490 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэсэн саналд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагад нөлөөлөхөөр байна гэж дүгнэсэн.

Уг дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтын дагуу 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаанд багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбогдуулан төсвийн хүрээний мэдэгдэл дэх эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд холбогдох өөрчлөлтийг хийх талаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагийн гаргасан саналтай холбогдсон тооцооллыг дахин нягтлах чиглэл өгч, төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар буцаасан.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр багш, эмч, эмнэлгийн ажиллагсад, төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийг

нэмэгдүүлэх асуудал шийдэгдэхээр болсон тул үүнтэй уялдуулан төсөлд дараах саналыг оруулж байна. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 их наяд 600 тэрбум гэснийг 31 их наяд 930 тэрбум гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд 30,9 хувь гэснийг 31,2 гэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1 их наяд 380 тэрбум гэснийг -1 их наяд 50 тэрбум гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд -1,3 гэснийг -1 гэж, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд 29 их наяд 552 тэрбум гэснийг 29 их наяд 859 тэрбум гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 28,9 гэснийг 29,2 гэж, нэгдсэн суурь тэнцэл 2 их наяд 48 тэрбум гэснийг 2 их наяд 70 тэрбум гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Сэддорж. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна.

12.00 цаг

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА